

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/060/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
4. Аудитын тайлан	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БАТСҮРЭН
ТАНАА

2026.02.24 № УВА-2026/060/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны Б/32, А/36 дугаар тушаалаар хагас, бүтэн жилийн үр дүнгийн урамшууллыг тухай бүр тооцон олгосон байна. Харин Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/37 дугаар тушаалаар илүү цагаар ажилласан нь цагийн балансгаар нотлогдохгүй байхад 29,458.2 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг нийт албан хаагчдад олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.12 дахь хэсэгт "Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэмэгдэл хөлс олгоно", Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.5 дахь хэсэгт "Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

8525050236

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,626,621.21	39,397,782.00
33	АВЛАГА	1,121,585.21	-
33500	Бусад авлага	1,121,585.21	-
33510	Байгууллагаас авах авлага	1,121,585.21	-
35	БАРАА МАТЕРИАЛ	39,505,036.00	39,397,782.00
35400	Хангамжийн материал	39,505,036.00	39,397,782.00
35410	Бичиг хэргийн материал	9,636,750.00	11,117,650.00
35420	Аж ахуйн материал	23,309,296.00	22,927,196.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,430,900.00	1,430,900.00
35450	Барилгын засварын материал	3,049,500.00	3,038,500.00
35470	Бусад хангамжийн материал	2,078,590.00	883,536.00
3695	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	463,935,724.96	473,091,437.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	463,935,724.96	473,091,437.45
39200	Биет хөрөнгө	448,935,724.96	458,091,437.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	412,362,579.00	412,362,579.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(65,029,796.68)	(76,339,326.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,996,000.00	17,996,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,699,399.97)	(6,298,599.93)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	150,645,105.90	204,949,620.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(77,590,826.76)	(102,168,911.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,279,332.00	38,019,032.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,777,268.53)	(34,678,955.78)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,500,000.00	7,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,750,000.00)	(3,250,000.00)
39300	Биет бус хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
39301	Программ хангамж	5,753,332.00	5,753,332.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,753,332.00)	(5,753,332.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00
395	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	504,562,346.17	512,489,219.45
40	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,732,691.63
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,732,691.63
41300	Өглөг	-	5,732,691.63
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	314,139.65
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,418,551.98
50	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	504,562,346.17	506,756,527.82
51	Засгийн газрын хувь оролцоо	504,562,346.17	506,756,527.82
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	341,279,770.77	341,279,770.77
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	341,279,770.77	341,279,770.77
51200	Хуримтлагдсан үр дүн	155,194,715.42	157,388,897.07
51210	Өмнөх үеийн үр дүн	155,194,715.42	155,194,715.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,194,181.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,087,859.98	8,087,859.98
60	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	504,562,346.17	512,489,219.45

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,006,613,400.00	2,065,468,160.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,530,800.00	58,590,960.00
3	Нийтлэг татварын бус орлого	2,530,800.00	58,590,960.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,530,800.00	58,590,960.00
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	57,223,700.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,530,800.00	1,367,260.00
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,004,082,600.00	2,006,877,200.00
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,582,100.00	64,239,600.00
9	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,062,600.00	64,239,600.00
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,519,500.00	-
11	Төсвийн захирагчдаас	1,939,500,500.00	1,942,637,600.00
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,939,500,500.00	1,942,637,600.00
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,031,235,027.51	2,063,273,978.35
14	УРСГАЛ ЗАРДАЛ	2,031,235,027.51	2,063,273,978.35
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,752,104,670.12	1,887,551,410.24
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,439,352,938.12	1,567,021,875.71
17	Үндсэн цалин	852,579,603.26	765,182,952.51
18	Нэмэгдэл	407,832,701.74	642,781,683.20
19	Унаа хоолны хөнгөлөлт	43,050,000.00	81,310,393.00
20	Урамшуулал	135,890,633.12	77,746,847.00
21	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,740,626.14	188,062,115.89
22	Тэтгэврийн даатгал	124,029,883.52	132,695,658.28
23	Тэтгэмжийн даатгал	14,963,246.94	15,229,970.29
24	ҮОМШӨ-ний даатгал	7,370,779.04	7,614,985.82
25	Ажилгүйдлийн даатгал	5,654,563.36	6,357,690.70
26	Эрүүл мэндийн даатгал	23,722,153.28	26,163,810.80
27	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,009,689.30	63,527,051.13
28	Гэрэл, цахилгаан	3,601,539.70	4,837,328.13
29	Түлш, халаалт	37,749,899.60	55,159,800.00
30	Цэвэр, бохир ус	1,658,250.00	3,529,923.00
31	Хангамж, бараа материалын зардал	17,855,857.84	6,444,785.00
32	Бичиг хэрэг	5,148,600.00	2,060,430.00
33	Тээвэр, шатахуун	3,484,750.00	-
34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,911,532.84	2,550,705.00
35	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	475,000.00	-
36	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,835,975.00	1,833,650.00
37	Эд хогшил, урсгал засварын зардал	4,735,500.00	2,410,000.00
38	Багаж, техник, хэрэгсэл	2,825,000.00	-

39	Урсгал засвар	1,910,500.00	2,410,000.00
40	Томилолт, зочны зардал	24,912,570.00	6,275,000.00
41	Дотоод албан томилолт	24,912,570.00	6,275,000.00
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,594,305.00	5,742,595.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	398,000.00	2,866,471.00
44	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	-
45	Даатгалын үйлчилгээ	-	98,010.00
46	Тээврийн хэрэгслийн татвар	72,100.00	65,800.00
47	Газрын төлбөр	150,000.00	150,000.00
48	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	372,800.00	-
49	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,737,405.00	2,562,314.00
50	Бараа үйлчилгээний бусад зардал	42,903,183.72	48,067,987.51
51	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,854,400.00	-
52	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,048,783.72	48,067,987.51
53	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,130,357.39	175,722,568.11
54	Бусад урсгал шилжүүлэг	232,247,792.00	84,144,471.98
55	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,806,000.00	1,892,000.00
56	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,340,700.00	66,790,472.00
57	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	181,101,092.00	15,461,999.98
58	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,882,565.39	91,578,096.13
59	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,882,565.39	90,648,631.78
60	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	929,464.35
61	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II)	(24,621,627.51)	2,194,181.65
62	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(24,621,627.51)	2,194,181.65

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	2,004,363,100.00	2,006,877,200.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,500.00	-
3	Нийтлэг татварын бус орлого	280,500.00	-
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	280,500.00	-
5	Бусад орлого	280,500.00	-
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,004,082,600.00	2,006,877,200.00
7	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,582,100.00	64,239,600.00
8	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,062,600.00	64,239,600.00
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,519,500.00	-

10	Төсвийн захирагчдаас	1,939,500,500.00	1,942,637,600.00
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,939,500,500.00	1,942,637,600.00
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,986,645,043.00	2,006,877,200.00
13	УРСГАЛ ЗАРДАЛ	1,986,645,043.00	2,006,877,200.00
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,707,514,685.61	1,834,992,803.87
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,439,698,799.33	1,565,586,150.85
16	Үндсэн цалин	725,047,482.00	763,852,663.86
17	Нэмэгдэл	520,557,898.33	642,676,246.99
18	Унаа хоолны хөнгөлөлт	55,282,000.00	81,487,570.00
19	Урамшуулал	138,811,419.00	77,569,670.00
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	170,654,444.14	188,062,115.89
21	Тэтгэврийн даатгал	118,840,822.52	132,695,658.28
22	Тэтгэмжийн даатгал	13,459,151.52	15,229,970.29
23	ҮОМШӨ-ний даатгал	6,657,575.83	7,614,985.82
24	Ажилгүйдлийн даатгал	6,279,377.09	6,357,690.70
25	Эрүүл мэндийн даатгал	25,417,517.18	26,163,810.80
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,009,689.30	63,527,051.13
27	Гэрэл, цахилгаан	3,601,539.70	4,837,328.13
28	Түлш, халаалт	37,749,899.60	55,159,800.00
29	Цэвэр, бохир ус	1,658,250.00	3,529,923.00
30	Хангамж, бараа материалын зардал	17,643,482.84	5,963,205.00
31	Бичиг хэрэг	8,448,850.00	2,126,830.00
32	Тээвэр, шатахуун	3,484,750.00	-
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,911,532.84	2,384,825.00
34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	475,000.00	-
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,323,350.00	1,451,550.00
36	Эд хогшил, урсгал засварын зардал	4,702,000.00	2,399,000.00
37	Багаж, техник, хэрэгсэл	2,825,000.00	-
38	Урсгал засвар	1,877,000.00	2,399,000.00
39	Томилолт, зочны зардал	24,912,570.00	6,275,000.00
40	Дотоод албан томилолт	24,912,570.00	6,275,000.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,758,800.00	3,180,281.00
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,299,900.00	2,866,471.00
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	-
44	Даатгалын үйлчилгээ	-	98,010.00
45	Тээврийн хэрэгслийн татвар	72,100.00	65,800.00
46	Газрын төлбөр	150,000.00	150,000.00
47	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	372,800.00	-
48	Бараа үйлчилгээний бусад зардал	2,134,900.00	-
49	Бараа үйлчилгээний бусад зардал	280,500.00	-
50	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,854,400.00	-
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	279,130,357.39	171,884,396.13

52	Бусад урсгал шилжүүлэг	232,247,792.00	80,306,300.00
53	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,806,000.00	840,000.00
54	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,340,700.00	64,004,300.02
55	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	181,101,092.00	15,461,999.98
56	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,882,565.39	91,578,096.13
57	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,882,565.39	90,648,631.78
58	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	929,464.35
59	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	17,718,057.00	-
60	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	17,506,205.00	-
61	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,506,205.00	-
62	Дотоод эх үүсвэрээр	17,506,205.00	-
63	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,506,205.00	-
64	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(17,506,205.00)	-
65	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	211,852.00	-

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	341,279,770.77	8,087,859.98	181,263,314.30	530,630,945.05
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,446,971.37)	(1,446,971.37)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	341,279,770.77	8,087,859.98	179,816,342.93	529,183,973.68
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(24,621,627.51)	(24,621,627.51)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	341,279,770.77	8,087,859.98	155,194,715.42	504,562,346.17
11	2025 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл	341,279,770.77	8,087,859.98	155,194,715.42	504,562,346.17
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	341,279,770.77	8,087,859.98	155,194,715.42	504,562,346.17
19	Тайлант үеийн үр дүн	-	-	2,194,181.65	2,194,181.65
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	341,279,770.77	8,087,859.98	157,388,897.07	506,756,527.82

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,958,035,000.00	1,851,988,968.22	106,046,031.78
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,958,035,000.00	1,851,988,968.22	106,046,031.78
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,868,810,300.00	1,771,682,668.22	97,127,631.78
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,575,914,700.00	1,511,217,491.85	64,697,208.15
5	Үндсэн цалин	762,891,900.00	763,852,663.86	(960,763.86)
6	Нэмэгдэл	594,281,800.00	588,307,587.99	5,974,212.01
7	Унаа хоолны хөнгөлөлт	94,545,300.00	81,487,570.00	13,057,730.00
8	Урамшуулал	124,195,700.00	77,569,670.00	46,626,030.00
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	197,166,200.00	181,120,639.24	16,045,560.76
10	Тэтгэврийн даатгал	134,638,000.00	127,793,726.44	6,844,273.56
11	Тэтгэмжийн даатгал	15,683,700.00	14,668,030.91	1,015,669.09
12	ҮОМШӨ-ний даатгал	7,841,700.00	7,334,015.81	507,684.19
13	Ажилгүйдлийн даатгал	7,797,200.00	6,118,363.38	1,678,836.62
14	Эрүүл мэндийн даатгал	31,205,600.00	25,206,502.70	5,999,097.30
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,689,700.00	63,527,051.13	1,162,648.87
16	Гэрэл, цахилгаан	5,683,400.00	4,837,328.13	846,071.87
17	Түлш, халаалт	55,159,800.00	55,159,800.00	-
18	Цэвэр, бохир ус	3,846,500.00	3,529,923.00	316,577.00
19	Хангамж, бараа материалын зардал	11,752,400.00	5,963,205.00	5,789,195.00
20	Бичиг хэрэг	3,723,700.00	2,126,830.00	1,596,870.00
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,817,600.00	2,384,825.00	432,775.00
22	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	537,500.00	-	537,500.00
23	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,673,600.00	1,451,550.00	3,222,050.00
24	Эд хогшил, урсгал засварын зардал	1,145,600.00	399,000.00	746,600.00
25	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	746,600.00	-	746,600.00
26	Урсгал засвар	399,000.00	399,000.00	-
27	Томилолт, зочны зардал	11,585,000.00	6,275,000.00	5,310,000.00
28	Дотоод албан томилолт	11,585,000.00	6,275,000.00	5,310,000.00
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,556,700.00	3,180,281.00	3,376,419.00
30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,240,000.00	2,866,471.00	373,529.00
31	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,160,900.00	-	1,160,900.00
32	Даатгалын үйлчилгээ	527,300.00	98,010.00	429,290.00
33	Тээврийн хэрэгслийн татвар	134,700.00	65,800.00	68,900.00
34	Газрын төлбөр	150,000.00	150,000.00	-
35	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,343,800.00	-	1,343,800.00
36	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,224,700.00	80,306,300.00	8,918,400.00
37	Бусад урсгал шилжүүлэг	89,224,700.00	80,306,300.00	8,918,400.00
38	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,741,000.00	840,000.00	4,901,000.00

39	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66,791,300.00	64,004,300.02	2,786,999.98
40	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,692,400.00	15,461,999.98	1,230,400.02
41	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,958,035,000.00	1,851,988,968.22	106,046,031.78
42	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,958,035,000.00	1,851,988,968.22	106,046,031.78
43	Улсын төсвөөс санхүүжих	1,958,035,000.00	1,851,988,968.22	106,046,031.78
44	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	78.00	78.00	-
45	АЖИЛЛАГСДЫН ТОО	39.00	39.00	-
46	Удирдах ажилтан	4.00	4.00	-
47	Гүйцэтгэх ажилтан	35.00	35.00	-
48	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39.00	39.00	-
49	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	35.00	35.00	-
50	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	4.00	-

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		<i>/төгрөгөөр/</i>
№	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	63,310,135.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63,310,135.65
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,310,135.65
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,310,135.65
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,310,135.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,310,135.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,310,135.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,368,659.00
210102	Нэмэгдэл	54,368,659.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,941,476.65
210201	Тэтгэврийн даатгал	4,901,931.84
210202	Тэтгэмжийн даатгал	561,939.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	280,970.01
210204	Ажилгүйдлийн даатгал	239,327.32
210205	Эрүүл мэндийн даатгал	957,308.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын газар нь байгууллагын манлайллыг дээшлүүлэх, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, төрийн албан хаагчдын ёс зүйг чанд сахиж иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон

нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,068.6 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,121.6	0.0	-1,121.6
Бараа материал	39,505.0	39,397.8	-107.2
Үндсэн хөрөнгө	463,935.7	473,091.4	9,155.7
Нийт хөрөнгө	504,562.3	512,489.2	7,926.9
Өр төлбөр	0.0	5,732.7	5,732.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	504,562.3	506,756.5	2,194.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	504,562.3	512,489.2	7,926.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлагын данс 1,121.6 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын данс 39,397.8 мянган төгрөг болж 107.2 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 473,091.4 мянган төгрөг болж 9,155.7 мянган төгрөгөөр өссөн нь 57,223.7 мянган төгрөгийн хөрөнгийг Нийгмийн даатгалын Ерөнхий газраас үнэ төлбөргүй шилжүүлэн авч, тайлант онд 48,068.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 506,756.5 мянган төгрөг болж 2,194.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,001,380.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 4,794.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,006,174.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 48,139.1 мянган төгрөгөөр бууруулж 1,958,035.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,939,500.5 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 1,958,035.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагаанд 1,851,988.9 мянган төгрөгийг зарцуулж 90,648.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71901-Нийгмийн даатгал 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,786,236.6	1,710,560.90	75,675.70	95.8%
2	80219- Харуул, хамгаалалтын зардал	3,240	2,867	373.50	88.5%
3	80224- Зөвлөл, хороо, комиссын гишүүд	79,334	58,255.30	21,078.40	73.4%
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	83,484	79,466	4,017.40	95.2%
5	80813-Хуульд заасан үндэслэлээр алба	4,901	0	4,901.00	0.0%
6	80820-Бусад тусламж, дэмжлэг	840	840	0.00	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/					
№	Үзүүлэлт	Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	0.00	0.00	-	Санхүүгийн тайланд 5,753.3 мянган төгрөгийн одоо ашиглагдахгүй программ байна. Тайлант онд программ хангамжид зардал гараагүй байна.
2	Унаа, хоолны зардал	88,431.3	81,487.6	(6,943.7)	НДЕГДаргын тушаал 2024.07.29 өдрийн А/135, НДЕГ-ын даргын 2025.02.11 А/26 тушаал
3	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	0.00	0.00	0.00	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.00	0.00	0.00	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.00	0.00	0.00	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тоо	42	39	3	НДЕГ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/239 дугаар тушаалаар 3 орон тоог хасаж 39 орон тоотойгоор бүтэц баталсныг хэрэгжүүлэн ажилласан байна.
7	Хэвлэл мэдээлэл	0.00	0.00	0.00	Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 64,239.6 мянган төгрөгийн орлогыг зарцуулах эрх нээлгэн 63,310.1 мянган төгрөгийг

зориулалтын дагуу зарцуулж, 929.5 мянган төгрөгийг орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хангамж бараа материалын зардал болох бичиг хэрэг, тээвэр шатахуун, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсэд нийт 7,391.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 19 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны төсвийн нийт зардлын 2,031,235.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 20,312.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,063,274.0 төгрөгийн 1 хувиар 20,632.7 төгрөгөөс 80 хувиар тооцож 16,506.2 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын газрын төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 164, хугацаа хоцроож 5 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.2 дахь заалтад “Дэд дарга, орлогчгүй, эсхүл эзгүй тохиолдолд байгууллагын даргын албан үүргийг чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлэх”, 43.3.3 дахь заалтад “Энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх” гэж заасан байхад Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/259 дүгээр тушаалаар Увс аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Нийгмийн даатгалын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 800.0 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 52 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	800.0	1	800.0	100%
Нийт дүн	1	800.0	1	800.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийгмийн даатгалын газрын Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно” гэж заасныг үндэслэн Татварын мэргэшсэн зөвлөх зэргийн нэмэгдлийг 15 хувиар тооцож 3,047.4 мянган төгрөг олгосон байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийг үндэслэн Зөвлөх мэргэшлийн зэрэг авсан нийгмийн даатгалын улсын байцаагчид олгох нэмэгдлийг 15-30 хувиар тооцож 57,182.9 мянган төгрөгийг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь хэсэгт “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс” бүрдэнэ гэж заасантай зөрчилдөж байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,505.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 32,505.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өглөө.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын газрын Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга нь Зөвлөх мэргэшлийн зэрэг авсан нийгмийн даатгалын улсын байцаагчид олгох нэмэгдлийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/29 дүгээр тушаалын дагуу үндсэн цалингийн 20 хувиар тооцож 4,063.2 мянга, Татварын мэргэшсэн зөвлөх зэргийн нэмэгдлийг газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар үндсэн цалингийн 15 хувиар тооцож 3,047.4 мянга, нийт 7,110.6 мянган төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн зүйлийн 57.2 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн цалин хөлс нь”, 57.2.2 дахь заалтад “Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс”, 57.2.4 дэх заалтад “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон бусад нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс тус тус бүрдэнэ”, 57.3 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагчид цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй”, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 4-д “Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж, төсвөөс хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахыг таслан зогсоож давтан гаргахгүй байхаар албан шаардлага өглөө.

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны Б/32, А/36 дугаар тушаалаар хагас, бүтэн жилийн үр дүнгийн урамшууллыг тухай бүр тооцон олгосон байна. Харин Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/37

Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг давхардуулсан олгосон байна.	1	3,047.4			1	3,047.4					
Хууль зөрчин нэмэгдэл хөлс олгосон байна.	1	29,458.2			1	29,458.2					
Дүн	2	32,505.6			2	32,505.6					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР *[Signature]* /Р.АЮУШ/



2026 оны 02 сарын 24-ний өдөр

